**МОНГОЛ УЛСЫН**
**СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ**
**ТОГТООЛ**

2021 оны 3 сарын 04 өдөр                Дугаар 26                Улаанбаатар хот

**Зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн хавсралтад дурдсан сумдын багуудад сонгогчдоос санал авах, тоолох зорилгоор шинээр хэсэг байгуулахыг тухайн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд зөвшөөрсүгэй.

2.Шинээр байгуулагдсан хэсгийн талаарх мэдээллийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэст хүргүүлэхийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА                П.ДЭЛГЭРНАРАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА                Д.ДАВАА-ОЧИР

0000051

Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 3. дугаар сарын 04-ны өдрийн 26 дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИАР ШИНЭЭР БАЙГУУЛАХ ХЭСГИЙН ЖАГСААЛТ**

| № | Аймгийн нэр | Байгуулагдсан хэсэг | | Сонгогчийн тоо | Шинээр байгуулагдах хэсэг | | Сонгогчийн тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | сум | баг | | | | |
| 1 | Архангай | Хангай | Гичгэнэ 2-р баг<br>Баян-Улаан 4-р баг | 493 | 1 | Гичгэнэ 2-р баг | 197 |
| 2 | Завхан | Дөрвөлжин | Онц 5-р баг<br>Тавантолгой 3-р баг | 442 | 2 | Онц 5-р баг | 197 |
| | | Цагаанчулуут | Баянхайрхан 4-р баг<br>Жавцаг 2-р баг | 375 | 3 | Жавцаг 2-р баг | 185 |
| | | | | | 4 | Баянхайрхан 4-р баг | 190 |
| 3 | Сүхбаатар | Халзан | Сахиул 1-р баг<br>Сайн шанд 3-р баг | 363 | 5 | Сахиул 1-р баг | 190 |
| 4 | Хэнтий | Цэнхэрмандал | Нугаар 2-р баг<br>Согоот 3-р баг | 567 | 6 | Нугаар 2-р баг | 191 |
| 5 | Булган | Баян-Агт | Дулаанхаан 4-р баг<br>Халтар 5-р баг | 440 | 7 | Халтар 5-р баг | 167 |
| 6 | Ховд | Мөст | Баянхайрхан 3-р баг<br>Давс 4-р баг | 456 | 8 | Давст 4-р баг | 178 |
| 7 | Баянхонгор | Баацагаан | Могой 4-р баг<br>Буйлсан 3-р баг | 414 | 9 | Могой 4-р баг | 180 |